

December 27, 1962

**Memorandum of conversation, Mongolian Prime
Minister Yumjaagiin Tsendenbal and Chinese Prime
Minister Zhou Enlai**

Citation:

"Memorandum of conversation, Mongolian Prime Minister Yumjaagiin Tsendenbal and Chinese Prime Minister Zhou Enlai", December 27, 1962, Wilson Center Digital Archive, Mongolian Foreign Ministry archive: fond 5, dans 1, kh/n 283. Obtained by Sergey Radchenko. <https://wilson-center-digital-archive.dvincitest.com/document/134680>

Summary:

Discussion of Sino-Mongolian economic relations (in particular, the Chinese workers' problem), and the Sino-Soviet disagreements, in particular concerning the Albanian question.

Original Language:

Mongolian

Contents:

Original Scan

- 988 -

МОН ПУУН

ЯРИАНЫ ТЭМДЭГЛЭЛ

1962 оны 12 дугаар сарын 27.

Бээжин

Утга нь: БНХАУ-ын Төрийн Зөвлөлийн ерөнхий сайд нөхөр Чжоу Энх-лай нөхөр Ю.Цэдэнбалд дахин бараалхсант у х а й

Нөхөр Чжоу Энх-лай энэ өдрийн 14 цаг 30 минутанд Цэдэнбал даргын байрлаж байгаа байранд ирж бараалхав.

Ингэж бараалхахад Монголын талаас: БНМАУ-ын Сайд дарын Зөвлөлийн орлогч дарга нөхөр Н.Жагварал, Гадаад Явдлын Яамны сайд П.Шагдарсүрэн, мөн яамны орлогч сайд С.Сосорбарам, Элчин Сайд Д.Цэвэгмид, Ардын Их Хурлын депутат С.Батаа, Гадаад Явдлын Яамны хэлтсийн эрхлэгч Чимиддорж нар.

Хятадын талаас: Гадаад Явдлын Яамны орлогч сайд Цэн Пын-фэй, БНХАУ-ын Төлөвлөгөөний Комиссын гадаад орнуудтай эдийн засгийн талаар харилцах асуудал эрхэлсэн орлогч дарга *Фан И*, Хятадын Гадаад Худалдааны Яамны орлогч сайд Ли Чан, Хятадын Гадаад Явдлын Яамны Азийн хоёрдугаар хэлтсийн эрхлэгч Жоу Чю-Е, мөн яамны Эслолын хэлтсийн эрхлэгч Юй Пэй-вэнь, Элчин Сайд Се Фу-шэн нар байлцав. Яриэг хятадын талын орчуулагч Эрдэнэбулга орчуулав. Тэмдэглэлийг Гэгээнхүү, еер нэг хятад ажилтны хэлт хийж байв.

ЧЖОУ ЭНХ-ЛАЙ: Танай хичнээн оюутан энд суралцаж байна вэ?

ЦЭДЭНБАЛ: Бээжинд 40 гаруй гэсэн байх аа.

ЧЖОУ ЭНХ-ЛАЙ: Өөр хотонд танай оюутнууд буй байх аа?

ЦЭДЭНБАЛ: Шанхай, Кантон, Тянь-Цзинь хотуудад бий.

ЧЖОУ ЭНХ-ЛАЙ: Дарга та ирсэн учраас танай Элчин сайдын яам их ажилтай байгаа байх аа?

ЦОДОНБАЛ: Элчин Сайд Яам их амжилтай байх ёстой. Энэ бол үүрэг нь юм.

ЧХСУ ЭНЬ-ЛАЙ: Нийт орутан практикийн хүмүүс хэд вэ?

ЦОДОНБАЛ: Нийт 70 гаруй хүн бий?

ЧХСУ ЭНЬ-ЛАЙ: Манай энд байгаа танай хүмүүс уур амьсгал, хоол ундны талаар дасч байгаа болов уу?

ЦОДОНБАЛ: Дасч байна.

ЦОДОНБАЛ: -Бээжин агаар улирлын хувьд Хятадын дунд районд орох уу?

ЧХСУ ЭНЬ-ЛАЙ: -Хойт районд орно. Шар мөрөнөөр өмнөт, хойт гэж хуваадаг. Өнөөдөр ечигдөрийн яриаг үргэлжлүүлье.

Эдийн засгийн талаар тавьсан асуудалд хариу өгье. Худалдааны талаар Монголын талаас манайд нийлүүлж байгаа бараа бага байна. Манайхаас танайд нийлүүлж байгаа бараа илүү байгаа юм байна. Төмөр замаар тээвэрлэх бараа сүүлийн жилүүдэд хасагджээ. Манайхаас төлөх зүйл бага болж байна.

ЦОДОНБАЛ: -Манай талаас төлөх зүйл илүү байгаа биз дээ.

ЧХСУ ЭНЬ-ЛАЙ: -Тийм ээ. Энэ талаар би бодов. Ирэх жилээс эхлэж, танай нутгаар гарах төмөр замын тээврийг нэмэгдүүлэх бодлоготой байна. Тэхлээр танай орлого нэмэгдэх байх аа. Танайд нийлүүлэх зарим барааны хувьд хэмжээний талаар хомс байна. Зарим зүйл, жишээ нь цагаан будаа хэрэгтэй бол нийлүүлж болно. Цай, торго буюу торгомсг зүйлийг нийлүүлж болно. Энэ талаар танай хэрэгцээг аль болохоор кангаж болно. Хязгаартай гэж байгаа зүйл бол бүс барааны зүйл байна. Хөвөнгийн ургац сүүлийн гурван жил муу байсан. Энэ жил ч муу байна. Үүний гол шалтгаан бол хөвөнгийн ургац нь үр тарианы ургацээс шалтгаална. Манай улсад ихэнх газар үр тариа тариад мөнгөн тариа төлсөй бага болсон. Манай үйлдвэрлэж байгаа бүс бараа жилдээ нэг хүнд 5 метр ч хүрэнгүй

байна. Түүнээс болж танайд манай нийлүүлж байгаа зүйл бага боловч манайхаас гаргахад хэцүү байна. Та үүнийг зөв ойлгох байх аа.

Гэвч бид аль болохоор нилээд хэмжээгээр хангахыг бодно. Тодорхой асуудлыг худалдааны нөхөд хоорондоо ярьж тохирох биз ээ. Манайд танайхаас төлөх өрийн тухайд бол одоо төлөх хэрэгтэй гэхгүй. Тэр хэвээрээ үлдэж болно. Танай нутгаар яваа төмөр замын тээврийн орлогоос ч төлж болно. Адуу нэмж өх гэсэнд талархлаа илэрхийлье.

МЭДЭНБАЛ: -Адууг нэмэх бололцоо бий.

ЧКСУ-ЭНЬ-ЛАЙ: Бэрхшээлтэй бол битгий зовоорой

МЭДЭНБАЛ: -Нэмэгдүүлж болно.

ЧКСУ ЭНЬ-ЛАЙ: -Эдийн засгийн хамтын ажиллагаа буюу танайд тусламж болгож өгч байгаа барилгын тухай ярья. Хэлэлцээр ёсоор барьсан зүйлийг Та мэдэж бий. 22 төрлийн барилга байгуулалт үлдэж байгаа юм байна. Үүнд буцалтгүй тусламжийн барилга орно. Гүйцээгүй барилга 3 байна. Баригдаагүй байгаа барилгын шалтгаан нь түүхий эд, материалыг олоогүй, хайгуул-шинжилгээ хийгээгүй, зураг төслийг гаргаагүйтэй холбогдолтой юм байна. Зарим нэг барих гэж байгаа үйлдвэрийн түүхий эдийн талаар шийдвэрлэж болохгүй байна. Жишээ нь ургамалын тосны үйлдвэр гэхэд наран цэцэг, чихэрийн үйлдвэр байгуулахад чихэрийн манжин байхгүй байна.

Түүхий эдийг бий болгох хэрэгтэй. Энэ бол ^{орлог} дарга Жагваралд хамаарах зүйл биз дээ.

Шаазан, шилний үйлдвэр, металлын үйлдвэрийн тухай асуудал байна. Энэ талсаар түүхий эд холбогдолтой байна. Нарийн цавар, нарийн чулуу, төмрийн хүдрийн нооц судлагдаагүй байна. Үүнийг шийдвэрлээгүй юм байна. Энэ талаар нилээд бэлтгэл ажил хэрэгтэй юм байна.

Гэвч түүхий эдийн асуудал бол танай орны баялгаас болох юм. Гэсэн ч зарим нь танайд байхгүй зүйл байна. Жинээ нь хөрөнгө Зөвлөлт, Угтадын алинаас авахыг шийдэх хэрэгтэй. Та нөхөд ах дүү орноос авах байх аа. Жирийн нэг үйлдвэр байгуулахад жилд хоёр мянган тонн хөвөн хэрэгтэй юм байна. Үүнээс гадна зарим үйлдвэрийн газрын хоёрдугаар ээлж буюу өргөтгөх ажил байна. Тухайлбал цахилгаан станцын өргөтгөл зэрэг болно. Энэ талаар хоёр талын зохих байгууллагууд ярилцаж тохирох шаардлагатай байна.

Мөн түүнчлэн манай талаас тусламж болгож баригдсан зарим үйлдвэр зураг төсөл муу, барилгын чанар муугаас болж шинжлэх ухааны шаардлагыг хангаж чадахгүй болжээ. Жинээ нь Сүхбаатарын цаасны фабрик байна. Үүнийг бид өөрийн хөрөнгөөр шинээр байгуулж өгнө. Баригдах газрыг нь шилж олох болж байна. Танайд түүхий эд бий. Тусламжийн барилгын хувьд ийм байна. Тусламжийн барилга барьж байгуулах байгууллага бий. Түүнд таван мянган хүн ажиллаж бий. Тэнд байгаа тэдгээр хүмүүсийн жилийн ажлаас үзэхэд нэг жилд таван мянган хавтгай дөрвөлжин метр барилга барьж гүйцэтгэх чадалтай юм. Энэ бол биеэ дааж ажиллах барилгын байгууллага юм. Энэ байгууллагын хүч цаашдаа нэмэгдэхгүй байх болно. Одоогийн байдлаар манай улсын дотор үйлдвэрийг зохицуулж байгаа үед дээр дурдсан барилгуудыг хийх бэлтгэлийн талаас авч үзэхэд нилээд хугацаа хэрэгтэй юм байна. Барилгын хайгуул шинжилгээ хийх, зураг төслийг гаргах, тоног төхөөрөмжөөр хангах, ашиглалтад хүмүүсийг сургах зэрэг ажил их байна. Манай анхарах зүйл бол яс чанарын хувьд анхээръя. Үүнээс гадна барилгыг их талбай эзлүүлэхгүйг боцгоо. Дутагдал байвал сануулж байгээрэй. Ажлын

хэмжээнээс үзэхэд хүний тоог олшруулах хэрэгцээгүй байна. Энэ үндсэн дээр манай хоёр улсын холбогдох байгууллагууд бодит байдлаар ярилцан тохирох хэрэгтэй. Ажлын хэвийн байдал ба чанарыг хангахад онц анхаарах хэрэгтэй.

Дараагийн асуудал бол манайхаас танайд явуулж байгаа ажилчны асуудал юм. Энэ бол манайх урьд төдий л иийж бейгаагүй, туршлага байхгүй шинэ ажил юм. Энэ туршлага бол манай хоёр орны хооронд л байгаа юм. Бас Везлент Холбоот Улс ажилчин авэх хүсэлт тавьсан учраас бид нилээд ажилчдыг явуулсан юм. Хэдэн жилийн дараа тэд хэрэгцээгүй гэсэн учраас очсон ажилчны ихэнх нь буцаж ирсэн. Цөөн хүн тэнд бий. Монголын нөхцөл байдлаас болж /хүн цөөн, үйлдвэр, барилгын ажлын талаар туршлага багатай/ манай туслах явдал бол хөрш ёсны хэрэг. Манай ажилчид барилгаа дуусгаад хүмүүсийг сургахад тусалж өгөөд аажмаар нутагтаа буцах ийм зарчмыг баримталж ирсэн. Анх ажилчдыг танай улсад явуулахад манайхан энэ ажилд хөнгөн хандсан байна. 1955 онд ажилчин явуулахдаа таван жилийн дотор барьж байгуулах, хүмүүсийг сургах талаар амжих болов уу? гэсэн нь бүтсэнгүй. 1960 онд хэлэлцээ дахин үргэлжилсэн. Танай хүсэлтээр мөн хүмүүс явуулах болсон. Шинэ протокол байгуулсан. Анх хүн явуулахдаа цаг хугацааны талаар богино гэж манайхан боджээ. Одоогийн байдлаар хугацааг сунгах хэрэгтэй байна.

Ажилчны асуудлын талаар хоёрдугаар зүйл бол танайд байгаа ажилчид, танай ард түмэнтэй харилцах, харилцааны асуудал юм. Энэ тухай би эрэгцүүлэн бодож байсан юм. Хэдийгээр манай ажилчид пролетарийн интернационализмын үзэлтэй боловч хэл яриагаа ойлгоогүйгээс болж муу юм

гаргаж болох юм гэж бид бодож байсан юм. Энэ тухай танай Элчин Сайдуудтай ярьж байсан. Би хоёр удаа очихдоо тантай ч ярьж байсан. Анхны таван жил 1955-1960 онуудад иймэрхүү эвгүй явдлууд гарч байсан боловч, манай хоёр талын байгууллагууд энэ асуудлыг шийдвэрлэж байсан. Дараагийн онуудад ажил хаях зохисгүй явдлууд гаргах болжээ. 1961 оноос эхлэн зодох буюу зодогдох зэрэг ноцтой асуудлууд гарах болсон. Үүнээс болж ажилчид дургүйцэж, энэ дургүйцлээ ажлаа түр зогсоох, тийм хэлбэрээр гаргаж байсан байна. Өчигдөр дарга Цэдэнбал Та ажил хаях тухай ярьж байсан. Энэ тухай улс бүрт хууль бий байх аа. Бид еерийн ажилчдыг хүмүүжүүлэхдээ юуны өмнө ажиллаж байгаа улсын хууль ёсыг дагахыг шаарддаг. Гэвч хэл мэдэхгүйгээс болж танай хэв заншил, хууль дүрмийг мэдэхгүй тал байж болно. Та үүнийг зөв ойлгохыг хүсэж байна. Харин манай хувьд бол ажилчид, үйлдвэр заводын захиргаад ажлын нөхцөлөөр хангаж өхгүй бол эсэргүүцэл тавьж, ажлаа зогсоохыг зөвшөөрдөг юм. Гэвч үүнийг хууль, захиргааны журмаар шийдвэрлэхгүй, харин ажилчны хангамжийг дээшлүүлэх, ажилчны байгууллагаас ажилчдад ухуулга хийх жинхэнэ ардчилсан ёсоор тэднийг сургаж хүмүүжүүлэхэд оршино. Тэхдээ манай дотоодын байдалд ийм арга хэмжээ авдаг юм. Үйлдвэр ба ажилчдын харилцааг сайжруулах, дутагдлыг ариутгах явдалд ажил зогсоох нь сайн үр дүнтэй болдог юм. Гэвч Танд тайлбарлахад бид еерсийн дотоодын арга маягийг танайд тулгаж хэрэглүүлэхийг бодож байгаа хэрэг бий ээ.

Манайх бол ажилчдын дотор гарч байгаа ийм зарим нэгэн асуудлыг холбогдох байгууллагууд ухуулах их ажил хийж зөвшөөрлөхдөг юм. Хэрэв эдгээр хүмүүс танай удирдлагын үгэнд

орохгүй бол хүмүүжил ухуулгын ажлыг зохиох хэрэгтэй. Харин тэд нар өөрийн үгийг зөв гээд байвал нутагт нь буцааж болох юм. Тэдний орыг нөхөн авч болно. Үүнээс гадна нэг зүйл байна. Энэ бол дахин ажилчдыг нэмж явуулахад бэрхшээл болж байгаа зүйл юм. Манай хоёр улсын баримталж байгаа улс төрийн бодлого ба үзэл суртлын ажилд харилцан адилгүй зүйл байгаа учраас манай хоёр улсад энэ нь шууд муугаар нөлөөснөх талыг харгалзах цаг болжээ. Юуны өмнө ах дүү намуудын хооронд зөрж байгаа асуудал байна. Жишээ нь Албанийн намын тухай асуудал юм. Манай нам, ах дүү намын хоорондох зөрөлдөөнтэй асуудлыг нийтийн өмнө илээр тавихыг хэзээ ч хүсдэггүй. Зөвлөлт Холбоот Улсын Коммунист Намын ХХП их хурал дээр би үг хэлэхдээ тийнхүү ил тавихыг хориглох буюу хооронд нь учры нь олуулахыг чармайсан боловч амжилт олоогүй. Эцсийн эцэст Зөвлөлт-Албанийн харилцаа их муу болжээ. Энэ нь ах дүү намуудын харилцааг муу болгоход хүргэж байна. Энэ асуудлын хувьд холбогдох орнууд, намууд яаж хандаж, ямар арга маяг хэрэглэж байгааг ярих хэрэгтэй байна. Манайхан бол Зөвлөлт-Албанийн аль алиных нь баримт материалуудыг нийтэлдэг. Солонгос, Бьетнамын намууд аль алиныг нь хэвлэдэггүй. Туравдахь арга бол Монгол Ардын Хувьсгалт Намын арга юм. Энэ талаар Албанийг шүүмжилсэн зүйлийг нийтэлдэг. Мөн өөрөө Албанийн намыг шүүмжилсэн зүйлийг нийтэлдэг. Энэ бол бидний баримталж байгаа шугам адил биш гэдгийг харуулж байгаа жишээ юм.

Хоёрдугаарт Хятадын Коммунист Намд холбогдох асуудал байна. Сүүлийн үед Хятадын Коммунист Намыг нэр цоож Европ-Өрнөдийн намуудын дотор /Итали, Чехын нам/ шүүмжлэх

явдал гаргаж байна. Хэвлэлдээ бичиж байна. Монголын намын сонинд Чех-аас тавьсан илтгэл буюу бусад зүйлийг нийтэлсэн байна. Тэхдээ манай улсаас энэ тухай гаргасан зүйл нийтлэг дээгүй байна. Монгол ч гэсэн шүүмжлэх хэсэгт багтаж байгаа учир үүнийг нийтэлсэн байх аа.

Зөвлөлтийн коммунист нам, нөхөр Хрущев, Дээд Зөвлөлийн хурал дээр ярьсан үгэндээ манай намыг нэр цохолгүй шүүмжилсэн байна. Үнэн хэрэг дээрээ тэд бол биднийг хэлсэн юм. Манай намаас марксизм-ленинизмыг баримтлан нийтэлсэн бичиг баримтууд бол Хрущевийн тавьсан асуудалд хариу болж байгаа юм. Эдгээр баримт бичгүүдийг танай сонинд нийтлээгүй.

Дээр дурдсан гурван хэлбэр бол зарим нь Албанийг шүүмжилдэг, зарим нь ах дүү намууд илэн далангүй ярьж зөвлөлдөх санал тавьдаг. Монгол Ардын Хувьсгалт Нам энэ асуудалд хэрхэн хандаж, юу гэж үзэх нь та нарын өөрсдийн хэрэг юм. Манай ах дүү намуудын хооронд тулган шаардах эрх хэнд ч байхгүй юм. Хятадын Коммунист Намаас явуулж байгаа бодлого, хайж байгаа арга зам бол дотоодын хэрэг ээ. Бусад ямар ч нам үүнийг зогсоох буюу хоригдох ямар ч эрх байхгүй. Ингэхдээ намын бодлого үзэж адилгүй байгаад ямар арга зам хэрэглэх тухайд гэвэл манай ах дүү намын дотор болж байгаа хэргийг аль болохоор дотроо шийдвэрлэж учраа олохоос биш, дэлхийд шуугиан тавьж, дайсны өмнө ил тавих нь зүй бус хэрэг гэж үзэх ёстой. Үүнд манай намын бодлого оршиж байна. Мөн еер талаар ах дүү намуудын хоорондох ажил бус санамын хувьд хоорондоо маргаж ярьсны үндсэн дээр ах дүү намын хүрээнд дотор асуудлуудыг шийдвэрлэж болно гэж үзэж байна. Улс төрийн бодлого, стратеги, тактикийн

асуудлыг хэлэлцэн шийдвэрлэж болох юм гэж үздэг. Намын хоорондох маргалдааныг өргөтгөж, улсын харилцааг муудуулж болсхгүй гэж бид үзэж байна. Манай хоёр намд улс төрийн чиглэлийн хувьд адил бус юм бий. Энэ асуудлыг Тантай ярилцах буюу саналаа солилцох тийм үүрэг аваагүй байна. Өнөөдрийн хувьд бол манай хоёр улсын харилцаа сайн байна. Нэн ялангуяа бидний үсэг зурсан гэрээ, манай хоёр ард түмний найрамдлыг цаашид хөгжүүлэхэд их ач холбогдолтой юм. Ийм найрамдалт харилцааны үндсэн дээр танайд туслахын тулд манайх ажилчид явуулж байна. Гэвч танайд явуулж байгаа улс төр, үзэл суртлын асуудлын талаар бидэнд тохирохгүй зүйл байна. Ийм учраас танайд ажиллаж байгаа ажилчдын дотор улс төрийн ажил зохиоход хэцүү байна. Учир нь манай хятад ажилчид танай хүмүүстэй хольцолдон ажиллаж байна. Тэд нар бол манай улсаас танайд ажиллаж байгаа дипломат буюу түр албан томилолтоор танайд очиж байгаа хүмүүс болон танайд сурч байгаа манай оюутан нартай ч адил биш юм. Эдгээртэй ажиллахад нэг чиглэлтэй байхад, танай аж ахуйн олон салбарт тархаж, монгол хүмүүстэй хольцолдсон ажилчидтай ажиллахад өөр байдалтай байна. Манай ажилчид бол танай бүх салбарт тархсан хүмүүс, тэд бол амьдрал, ажлын хувьд танай ард түмэнтэй нийлсэн. Хоёрт, танайд байгаа ажилчид манай барилгын трестэд очиж байгаа /Жил бүр 5000/ хүмүүстэй ч адилгүй юм. Трестэд ажиллаж буй хүмүүс бол өөрийн сонинг уншдаг. Тэд танай ард түмэнтэй хамтран ажиллаж, амьдарч байгаа биш, өөрийн захиргааны доор ажилладаг. Иймээс танайд ажиллаж байгаа 8000 ажилчид бол дээр дурдсан трестийн хүмүүстэй адилгүй юм. Тэд танай байгууллагат хувьнарлагддаг янз бүрийн

салбарт ажиллаж байна. Тэд танай хэл заншлыг ойлгохгүй байна. Бас тэд танай улсын дотор, танай байгууллагын дотор хийж байгаа ажлыг хийгээд зогсоогүй, танай хувиар ёсоор бусад улсаас танайд үзүүлж байгаа тусламжийн барилгууд дээр ч ажил хийж байна. Хүн бол улс төрийн талаар сэтгэдэг амьтан юм. Зөв бурууг ойлгодог, еэртөө тохирохгүй зүйд дургүйцдэг байна. Манай хоёр орон, намын хооронд тохирохгүй асуудал бий. Үүнийг сэхээтэн нарт ойлгуулахад амар. Харин тэнд ажиллаж бий ажилчдад ойлгуулахад хэцүү. Хятадын коммунист намын шүүмжилсэн зүйлийг уншихдаа тэд дургүйцдэг. Энэ нь манай хоёр орны нэгдэл нягтралд тус хүргэхгүй байж болно. Тэд танай бүтээн байгуулалтад тусалж байна. Тэд манай хэвлэлийг цаг тухайд нь авахгүй байна. Танай үйлдвэрчний Төв Зөвлөлийн "Ажилчны зам" сонин, манай сонин хэвлэлд нийтлэгдсэн зүйлүүдийг тавихгүй байна. Иймээс танайд ажиллаж буй 8000 хүнийг яах вэ? гэдэг асуудал гарна. Энэ асуудлыг бүх талаар шийдвэрлэх юм сан гэж бодож байна. Энэ хүмүүс бол эдийн засаг, санхүүгийн тусламжтай адилгүй, амьд хүмүүс юм. Улс төрийн талаар зөв буюу бурууг ойлгодог улс аа. Энэ талаар гарч буй асуудлыг зөв зохистой шийдвэрлэхгүй бол цаашид эвгүй юм гарч мэднэ. Урьд нь хүмүүсийн хоорондын харилцааны тухай зүйл яригддаг байсан. Одоо бол манай хоёр улсын харилцаанд холбогдох асуудал яригдаж байна. Хоёр улсын суртал нэвтрүүлэг адил биш байгаа учраас зарим нэг асуудал гарч байна. Миний ярих зүйл энэ байна.

ИДЭВХАЛ: -8000 ажилчдын тухай Та ямар саналтай байна вэ?
 ЧУХУ ЭНЬ-ЛАЙ-Вид байдлын тухай ярих. Чухам ийм байдалд яахад гэсэн таны саналыг сонсох гэж байна. Ажилчдын асуудлыг зохистой шийдвэрлэхгүй бол манай хоёр улсын харилцаанд эвгүй муугаар нөлөөлөх бий гэж би их сэтгэл зовж байна.

ИВБАЛ:

Төмөр замаар тээвэрлэх ачааг 1963 оноос эхлэн цаашид нэмэгдүүлнэ, худалдааны хэлэлцээрээр авах зарим барааг нэмэгдүүлнэ гэж нөхөр Чжоу Энх-лай Та хэлэв. Зарим барааны талаар Хятадын дотоодод байгаа бэрхшээлийг бидэнд тайлбарлав. Хэдий бэрхшээл байвч, мөн зарим нэр төрлийн барааг нэмэгдүүлж худалдах гэж байна. Ингэж байгаад талархлаа илэрхийлье. Хоёр улсын Засгийн Газрын хооронд байгуулсан хэлэлцээр ёсоор баригдах зарим үйлдвэрийн тухай нөхөр Чжоу Энх-лай Та ярилаа. Энэ талаар манай хоёр талын зохих байгууллагууд хэлэлцээ хийж байна. Тэр хэлэлцээг үргэлжлүүлж дуусгана гэж бодож байна. Энэ талаар түүхий эдийн нөөцийг бүрэн судлаагүй явдал байгаа юм. Үүнийг хэргэлзэн барихаар төлөвлөж байсан зарим үйлдвэрийг барихыг зогсоож, түүнд зориулсан хөрөнгийг өөр барилга байгууламжинд шилжүүлэхээр яригдаж байгаа юм. Энэ талаар хоёр талын зохих байгууллагын нөхөд зарим хэсгийг ярилцсан. Энэ дотор зарим үйлдвэрийг байгуулахад эдийн засгийн талаар ашиггүй гэж үзсэн юм бий. Жишээ нь шилний үйлдвэрийг жилд 500 мянган м² шил гаргах хүчтэйгээр манайх бодсон юм. Үүнийг нэг сая м²-аар бодлоо ч гэсэн ашиггүй юм гэж танай зохих байгууллагын нөхөд зөвлөж байна. Энэ бол зөв зүйтэй зөвлөлтөөн гэж бодож байна. Ийм бага хэмжээгээр барих нь үнэхээр ашиггүй юм. Төрчлөн металлургийн жижиг завод барих нь мөн эдийн засгийн талаар ашиггүй юм.

Хоёрдугаарт түүхий эдийн асуудал бүрэн судлагдаагүй, гагцхүү төмрийн хүдэр орох бич, бусад олон юм орох юм. Хятад-Монголын хэлэлцээрээр тоймолсон хөрөнгө ч түүнд хүрэхгүй юм.

Иймээс металлургийн заводад зориулагдсан хөрөнгийг ч эер юманд ашиглая гэж бодож байна. Иймэрхүү өөрчлөлтийн талаар нэгэнт хоёр талын байгууллагын явуулж буй хэлэлцээ үргэлжлэх байх аа. Барихаа больж байгаа үйлдвэрт зориулсан хөрөнгийг чухам юунд шилжүүлэх вэ? гэдгийг харилцан ярих болно. Ургамалын тосны завод, саахарын заводын талаар түүхий эдийн судалгаа гарсаггүй байна гэж Таны хэлдэг зөв. Наран цэцэгийг тарьж сураад тэр үйлдвэрийг байгуулах саналтай байна. Саахарын заводын хувьд бол эдийн засгийн тооцоог бодох хэрэгтэй юм.

Хөвөн, бүс барааны үйлдвэрийн талаар урьдаар түүхий эдийг шийдвэрлэх нь чухал гэж Таны хэлдэг зөв юм. Танай нөхөдтэй урьдчилж ярихад Хятадын тал хөвөн нийлүүлэхэд бэрхшээлтэй гэж ярьсан тал бий. Ингэхлээр түүхий эдийг чухам хаанаас авахаа шийдвэрлэж чадаагүй байна. Энэ комбинатын асуудлыг эцэс болгож, дараа шийдвэрлэж болно. Эдийн засгийн асуудлын талаар энэ байна.

ЧХУ ЭНЬ-ЛАЙ: Энэ тухай дахин үргэлжлүүлж ярих, хэлэлцээ хийхийг би зөвшөөрч байна.

ЧДЛ ИВАЛ: Үүний урьд манай нөхөд Бээжинд ирээд буцсан. Улаанбаатарт бас танай эдийн засгийн нөхөдтэй ярилцаж байна. Түүхий эдийн судалгааны асуудал удаашраад тэр асуудал шийдвэрлэгдэж чадаагүй байна.

ЧХУ ЭНЬ-ЛАЙ: Наран цэцэг, чихэрийн луувангийн талаар Та нар одоо нутагтаа туршиж болно шүү дээ. Бид мэрэгжилтэн явуулж болно. Туршиж тарихад хугацаа хэрэгтэй, лав нэг жил хэрэгтэй байх.

ЧДЛ ИВАЛ: Бид бага хэмжээгээр туршиж тарьж байгаа.

ЧХУ ЭНЬ-ЛАЙ: Үүнтэй чинь хөдөлмөрийн хүч холбогцсонтой юм.

ЧДЛ ИВАЛ: Амьжигчны хүчний асуудлын тухай ярья. Манай улс хөдөлмөрийн ресурсаар комос байна. Тиймээс

18.

бид хятадаас ажилчид авч манай бүтээн байгуулах ажилд туслалцуулж байна. Танай ажилчид их юм бүтээж байна. Үүний өмнө зарим ажил дээр тохиолдож гарсан асуудлыг хоёр талаас хавсраад шийдвэрлэж ирсэн юм. Сүүлийн үед /61 оноос гэж та зөв хэлж байна/ ноцтой асуудал гарсан гэж Таны хэлсэн зүйтэй, тийм асуудал гарсан. Хятад нөхөд заншил ба хуулийг мэддэггүй явдлаас ч болж байгаа байх гэж Та хэлж байна. Тийм явдал байсан байж болно. Мөн танай дотоодод зарим газар ажил зогсоохыг зөвшөөрдөг журмыг баримталсан байж болох юм гэж байна. Энэ ч үнэн талтай байж мэдэх юм. Гэхдээ танай дотоодод хэрэглэж байгаа энэ журмыг өөр улсын нутагт хэрэглэж болохгүй гэж таны хэлж байгаа зүйтэй байна. Манай нам, Хятадын коммунист нам зарим чухал асуудлын талаар харилцан адил биш үзэлтэй байгаа явдал үүнд нөлөөлж байна гэж таны хэлж байгаа зүйл эцсийн эцэст үндсэн гол шалтгаан болж байх шиг байна. Үүнээс болж хятад ажилчид дургүйцэх, ажил орхих явдал гардаг байна гэж та тэмдэглэж байна. Энэ үнэхээр тийм юм. Ийм байгаа юм. н.Чжоу Энх-лай Та намуудын хоорондын харилцааны асуудлын тухай ярьв. Үүнд Албанийн хөдөлмөрийн намын тухай ярьв. Манай Монгол Ардын Хувьсгалт Нам Албанийн хөдөлмөрийн намын удирдагчдын талаар баримталж байгаа үзлээ зөв гэж үзэж байна. Албанийн удирдагчдын үйл ажиллагаа үнэхээр хэрэг дээрээ коммунист хөдөлгөөний нэгдэл нягтралыг сулруулахад задруулахад чиглэж байгаа юм. Тэд нар энэ үйл ажиллагаагаараа марксизм-ленинизм, пролетарийн интернационализмын зарчмаас үнэхээр унгарч байгаа юм. Үүнийг манай нам зүүжжигсэн. Түүнийг тэр бид зөв гэж үзэж байна. Дараа ч коммунист хөдөлгөөний нэгдэл нягтралд хэрэг үзэлтэй тэмцэл

явдлыг еерийн ариун зорилго гэж үзэж байна. Намуудын хоорондох зөрөлдөөнтэй асуудлыг дайсны өмнө ил тавихгүйгээр ярилцвал зохих юм гэж н.Чжоу Энх-дэй Та ярьж байна. Энэ талаар зөрөлдөөнтэй асуудлыг юу өмнө намууд хоорондоо харилцан ярилцах нь зүйтэй байна. Энэ талаар Албанийн удирдагчидтай ЗХУКН-ын удирдагчид, олон удаа ярих гэж оролдсон байна. Үүнийг та ч мэднэ. Бид ч мэднэ. Энэ тухай баримтууд ч байгаа. Олныг дурдахыг больё. Би ганц баримт дурдая. 1960 оны Москвагийн зөвлөлгөөний үеэр Албанийн удирдагчидтай ЗХУКН-ын удирдагчид хэд хэдэн удаа ярихыг оролдсон. н.Хрущев, Микоян болон бусад нөхөд Ходжа, Шеху нарыг урьж ярьсан нэг ярианы тэмдэглэлийг намын төлөөлөгчдөд тараасан. Энэ бол танайд ч бий, манайд ч бий, бусад намуудад ч бий. Тэр ярианы байдлаас үзэхэд Албанийн удирдагчдын зан байдал тод харагдаж байна. Тэд хүнийг яриулахгүй хашгирсаар байгаад яриа дуусаагүй байхад хаалга тас хаяад алга болсон.

Танай нам манай намын хооронд орчин үеийн зарим чухал асуудлын талаар өөр үзэлтэй, зөрөлдөөнтэй байна. Бид энэ асуудлаа эв зүйн ёсоор, хүний ёсоор Та бид ярилцаж байна шүү дээ. Албанийн удирдагчид тэгээгүй юм. Тэд үнэхээр хүүхдийн байдал гаргасан юм. Хашгирч байгаад хаалга тас хаяад гарах нь мууХай юм шүү дээ. Түүний дараагаар ч зөвлөлтийн нөхөд уулзая гэж санал тавьсан. Түүнийг зөвшөөрөхгүй зөвлөлгөөнийг орхмод явсныг бид мэдэж байна. Ийм олон удаагийн оролдлого хийж ядсаны дараа ХХП их хурал дээр тэдний үйл ажиллагааны тухай хэлсэн юм шүү дээ. Энэ асуудал бол зөвхөн Зөвлөлт-Албанийн тухай асуудал биш юм. Албанийн удирдагчид, бусад ах дүү намууд болон бид

-78

15.

коммунист хөдөлгөөн рүү довтолж байгаа юм. Энэ бол коммунист хөдөлгөөний нэгдлийг л задруулахад чиглэсэн үйл ажиллагаа юм, өөрөөр дүгнэх арга байхгүй.

Албанийн удирдагчдыг хөөрүүлээд байвал хөөрөөд л байх улс байгаа юм. Сүүлийн үед тэд нар империалист, тэдний дуу хоолойгоо нийлүүлээд ЗХУИИ, ах дүү бусад намууд, бүх коммунист хөдөлгөөнийг гүтгэж байна. Бас шууд хатгалгын чанартай ч ажил явуулж байна. Тэдний коммунист хөдөлгөөнөөс ухарсан нүүр царай ил тод харагдаж байна. Чжоу Энх-лай дарга та хэлэхдээ монголын нам зөвхөн Албанийг өөрөө шүүмжлээд байгаа буюу түүнийг шүүмжилсэн материалыг хэвлээд, Албанийн өөрийн нь материалыг хэвлэхгүй байна гэж дурдаж байна. Коммунист хөдөлгөөний нэгдэл нягтралыг задруулахад чиглэсэн Албанийн бузар гүтгэлтийн материалыг бид хэвлээгүй. Цаашид ч хэвлэхгүй. Хэрэв хэвлэвэл бид тэдний шугамыг зөвшөөрч байгаа хэрэг болно. Бид тэдний шугамыг зөвшөөрөхгүй. Ер нь марксизм-ленинизмын сургаалд харштай, коммунист хөдөлгөөний нэгдэл нягтралд харштай материалыг бид хэний ч байлаа гэсэн хэвлэхгүй. н. Чжоу Энх-лай хэлэхдээ Монголын сонин Чехословакийн коммунист намын материалыг нийтлээд хятадын коммунист намын материалыг нийтлэхгүй байна гэж байна. Тэхлээр хятадын коммунист нам орчин үеийн чухад асуудлуудаар зөв биш шугам баримталж байгаа гэдгийг намуудын зөвлөлгөөнөөр шүүмжилсэн. Түүний дотор манай нам ч шүүмжилсэн. Тэр шүүмжлэлээ бид зөв гэж үзэж байна. Тэр алдаатай зүйлийг баримталсан, түүнийгээ давтсан тийм материалыг бид хэвлэхгүй.

/Энд үед Чжоу Энх-лай дарга уурласан байдал гаргаж байв/ Бид нэр манай нам хятадын

-79-

16.

коммунист нам ба түүний удирдагч та бүхнийг ихээхэн хүндэтгэж үздэг. Одоо ч тэгэж үзэж байна. Танай нам бол олон жилийн турш хүнд бэрхшээлийг давж ирсэн нам юм. Ангийн ширүүн тэмцлийн дундуур гарч бэхжиж ирсэн нам юм. Ингээд зарим нэг орчин үеийн чухал асуудлын төлөөр баримталж байгаа алдаатай шугамсаа шүүжлэн үзэх явдал зүйн хэрэг юм гэж найдаж байдаг. Одоо ч найдаж байна. 1960 оны номуудын төлөөлөгчдийн зөвлөлгөөний мэдэгдлийг нэг саналтай батлах талаар танай нам чухал хувь нэмрээ оруулсан юм. Манай зорилго бол тэр үеийнхээ байдлаас ухрахгүй түүнээс улам урагш давшинд оршино. н.Чжоу Энх-лай, намайг асуудлыг журмагтаж байна гэж битгий ойлгоорой. Үнэн юмыг бид үнэнээр ярьж байна. Энэ зүгээс авч үзвэл танайх Албанийн удирдагчдыг дэмжиж байгаа шүү дээ. Тийм учраас тэд давраад цэвшдээ хөөрөөд байгаа юм.

Хятад ажилчид таны хэлсэн ёсоор үнэхээр манай хөдөлмөрчидтэй нийлж тэдний дотор хутгалдаж ажиллаж байгаа юм. Энэ үнэн. Манай нам бол өөрийн хөдөлмөрчдийн дотор баримталж байгаа бодлогоо ухуулна. Тэр бодлогоо сурталчлана. Марксизм-ленинизмын үзэл санааг сурталчлана. Хятад ажилчдыг амиллуулахын нөхцөл болгон манай нам үзэл суртлаасаа ухарч чадахгүй юм. Манайд ажиллаж байгаа хятад ажилчдын дотор манай намын байгууллагууд тусгайд нь суртлын ажил зохиодоггүй. Тэр ажлыг хятад ажилчдын хэрэг эрхлэх газраас зохиодог юм. Жинхэнэ тэд нарын гүйцэтгэх ажилтай холбогдсон зүйлийг хоёр төлөөс хамтарч тэдний дотор танууддаг. Энэ талаар хоёр тал хамтраад ажиллаж байна. Монгол байгууллагад ажиллаж байгаа хятад ажилчид

-70-

17.

хятадын трестэд ажиллаж байгаа хятад ажил-
чидтай адил биш гэдэг үнэн. Трестэд ажиллаж
байгаа хятад ажилчид монголчуудтай холилдох-
гүй байгаа юм. Манай хэлэлцээрийн ёсоор ажиллаж
байгаа ажилчид холилдож байдаг юм. Манай нам
марксизм-ленинизмын сургаалыг сурталчлах
түүнээс үндэслэсэн бодлогоо сурталчлах нь
зайлшгүй юм. Үүнийг бид еерийн ариун зорилго
гэж үзэж байна. Харин энэ талаар дутагдал
байвал түүнийг засаж ажлаа улам сайжруулах
ийм л зорилготой байна. Манай байгууллагад
ажиллаж байгаа хятад ажилчид манай намын
ухуулга суртлын ажлыг сонсоод дургүйцэх юм
гэж бодоод бид тэр ажлаа зогсоохгүй. Энэ
ажилчид бол хоёр улсын засгийн газрын хэлэл-
цээгээр ажиллаж байгаа улсууд юм. Энэ хэлэл-
цээр ёсоор тэр ажилчид ажиллах нь чухал гэж
үзэж байна. Үүнээс болоод бид хоёр тийшээ
хараад ажилчдын дотор гарч байгаа эвгүй явдал
улам олноор, улам хүчтэй болоод байх юм
гэж бид итгэхгүй байна.

ЦХОУ ЭНЬ-ЛАЙ: Би танаас нэг зүйл асууя. Танай сонинд хятадын
коммунист намыг шүүмжилсэн зүйлийг бичвэл
манайхаас танайд ажиллаж байгаа хятад ажилчид
яах вэ? /Уурлан маргалдаж эхлэв/

ЦЭДЭНБАЛ: Тийм бэрхшээл байгааг бид үгүйсгэхгүй байна
шүү дээ.

ЦХОУ ЭНЬ-ЛАЙ: Энэ асуудлыг яаж шийдвэрлэх юм бэ?

ЦЭДЭНБАЛ: Би таны энэ хэлж байгаа зүйлийг ажилчин
нэмэж өхгүй гэж байна гэж ойлгож байна. Зөв
үү?

ЦХОУ ЭНЬ-ЛАЙ: Энэ тухай яриад яахав. Таны ярьсныг би ойлго-
сон. Таны үзлийг би ч еерчилж чадахгүй, Та
миний үзлийг еерчилж ч чадахгүй. Би шинэ

-81-

18.

ажилчдын тухай яриагүй. Харин одоо ажиллаж байгаа 8000 ажилчдыг яах вэ?

ЦОДОНБАЛ:

Шинэ ажилчид нэмж өхгүй болж л дээ. Энэ асуудал ойлгогдлоо. Одоо байгаа 8000 ажилчдыг яах вэ? гэж ярьв. Тэр ажилчид тийм болно гээд бид суртлаасаа ухарч чадахгүй. Ажилчдын санаанд тохируулж манай нэм суртлаа өөрчилж чадахгүй.

ЧХОУ ЭНЬ-ЛАЙ:

Таныг шугамаа өөрчил гэж би хүсээгүй байна шүү дээ! Та намайг шугамаа өөрчил гэж яриад өөрийгөө ёстой марксист гээд байна шүү дээ. Өнөөдөр би таныг ер шүүмжлээгүй, та л намайг шүүмжлээд байх юм.

ЦОДОНБАЛ:

Таны сэдэж гаргасан асуудалтай холбогдуунж л би ярьсан шүү дээ. Тэр асуудалд л би харну өгч байна.

ЧХОУ ЭНЬ-ЛАЙ:

Миний ярьсан юманд шууд шүүмжилсэн юм байхгүй, ийм бэрхшээл байна, хоёр улсын харилцааны асуудлыг яаж шийдвэрлэх вэ? гэж ярьсан. Та л намайг сургах гээд байна шүү дээ. Таны сургаалыг би хэрхэвч хүлээж авахгүй.

ЦОДОНБАЛ:

Би сургах гэж яриагүй.

ЧХОУ ЭНЬ-ЛАЙ:

Сая та шугамаа өөрчилж өөрийгөө шүүмжил гэж хэлээд байна шүү дээ.

ЦОДОНБАЛ:

Коммунист намуудын зөвлөлгөөн дээр ярьсан зарчмын юмыг л би ярьж байна шүү дээ.

ЧХОУ ЭНЬ-ЛАЙ:

Би Москвагийн тунхагийг ер нь зөрчөөгүй. Хрушев ба түүнийг дагалдаж байгаа хүмүүс л зөрчөөд байна шүү дээ, гээд уурлан суудлаасаа өндөргөв.

ЦОДОНБАЛ:

Та уурлаад хэрэг алга. Зүгээр тайван ярь. Зөвлөлтийн коммунист немийн тусламжтайгаар манай нам байгуулагдаж өссөн. Одоо ч зөвлөлтийн коммунист немийг манай коммунист хөдөлгөөний манлай гэж манай нам үзэж байна. Коммунист

ЧХОУ ЭНЬ-ЛАЙ: Ямар зурам хэрэгнэх вэ? Би бол бэрхшээл байгаасгүй танд тэйдбэрлэсэн, та ойлгосон биз дээ. 30-40 минутын турш та намайг сургах гээд байв.

ЧХОУ ИВАЛ: Бид танай нам, танай тэмцэл, та нарыг хүндэтгэдэг. Та нар биднээс туршлагатай гэдгийг би ечигдөр танд хэлсэн, би бол марксизм-ленинизмийн сургаалын цагаан толгойг эхэлж байгаа хүн.

ЧХОУ ЭНЬ-ЛАЙ: Та их нэрэлхэж байна. Та нэг улсыг удирдаж байгаа шүү дээ.

ЧХОУ ИВАЛ: Саналаа ингэж солилцсон явдал ашигтай болно...

ЧХОУ ЭНЬ-ЛАЙ: Миний асуудалд та тодорхой хариу өгөөгүй шүү, бид ердийн байдлыг танд танилцуулсан юм шүү. Би ямар ч шаардлага тавиагүй, Та л намайг шүүмжлээд өөрийн үзлийг ил тавиад байна шүү дээ. Ах дүү намуудын хоорондын энэ асуудал Албанийн намын тухай асуудлыг Москвагийн зөвлөлгөөнөөр шийдвэрлэсэн гэж би үзэж байна. Москвагийн мэдэгдэлд ах дүү намын асуудлыг зөвлөлдөн ярилцаж шийдвэрлэх ёстой гэсэн. Бид тэр зарчмыг баримталж байна. Бид 61 оноос эхлээд Зөвлөлтийн коммунист намыг өөрөө Албанийн хөдөлмөрийн намтай ярилцаж дотроо асуудлаа шийдвэрлээрэй гэж саналаа тавиад байсан. Та бол Москвагийн зөвлөлгөөнөөс өмнө болсон юмны тухай ярьж байна. Манай санаачлагыг зөвлөлтийнх хүлээж аваагүй. Тэгсэн мөртлөө Зөвлөлтийн коммунист намын XXII их хуралд Албанийн төлөөлөгчдийг уриагүй ба нэг нам нөгөө намаа шүүмжилж дайсны өмнө хоорондын зөрчлийг ил тавьсан байна. Иймээс манай үзэж байгаагаар бол Зөвлөлт-Албанийн намын хоорондын зөрчил асуудлын уг шалтгаан ба алдаа нь зөвлөлтийн коммунист намд байна гэж би үзэж байгаа ба цаашид ч үзэж болно. Бусад ах дүү

-59-

21.

намууд хятадын коммунист нам руу ил довтолж
 байна. Бид манай намын шугам Москвагийн тун-
 хат мэдэгдлээс гахаагүй гэж үзэж байна.
 Зарим ах дүү намаас Манай намыг шүүмжилж
 байгаа, тэр бол гүтгэлэг юм. Үнэн мөнд нийцэ-
 гүй зүйл. Зарим зүйл нь тэдгээр намууд ба
 хүмүүсийн алдаа байгаа юм. Учир байдал ийм
 боловч манай ах дүү намуудын асуудлыг хоорон-
 доо шийдвэрлэх гэсэн саналыг бид одоо ч
 баримталж байна. Чехословакийн коммунист намын
 хурал дээр ^{Манай} СЮ-Цуанаас санал тавьсан. Энэ
 саналаа одоо ч бид хатуу баримталж байна.
 Өнөөдөр н.Цэдэнбал дарга танд ярихад манай
 намын зарчим марксизм-ленинизмын зарчим,
 Москвагийн баримт бичигт нийцэж байгаа юм.
 Хэрэв алдаатай гэж үзвэл тэр алдааг хятадын
 коммунист нам гаргаагүй. Хятадын коммунист
 намыг шүүмжилж байгаа намууд л гаргаж байгаа
 юм. Өнөөдөр цагаас болж энэ тухай ярихаа
 болъе гэж бодож байна. Хэрэв шаардлагатай
 бол ах дүү намуудын зөвлөлгөөн дээр ярьж
 болно. Түүнээс өмнө манай хоёр намын хооронд
 ч тусгай ярьж болох юм. Өнөөдөр тантай ярьсан
 гол зүйл бол хоёр улсын харилцаанд муу нөлөөл-
 гэж бодож яриагүй юм. Намын харилцааны асууд-
 лыг бид ярихыг бодоогүй, үүнийг би танд
 хэлсэн. Гэвч та манай намын шугамыг буруу
 гээд дахиж хянах хэрэгтэй гээд байна шүү дээ.
 Би бол танай нам буруу шугам баримталж байна
 гэж бодож байна. Гэвч танай нам шугамаа өөрч-
 лөөсөй гэж би тэгэж бодоогүй. Тэгэж бодож
 шаардах эрх ч үгүй. Харин ах дүү намуудын
 зөвлөлгөөн болохоор та намайг битгий битүүхэн
 шиг нударчхаарай. 60 оны зөвлөлгөөн дээр
 намайг Албанитай хамт яв гэж Чжоу Энй-лай
 хэлсэн гэж та хэлсэн шүү. Би бол Албани

дотоодынхоо хүчээр хөгжиж байгаа л гэж танд ярьж байсан. Энэ тухай тайлбарлахгүй бол Чжоу Энх-лай намайг хятадын коммунист намтай хамт яв гэж олон удаа хэлсэн гэж та хэлэх байх шүү. Бид еерийн шугамыг еерчлэхгүй. Таны еерчил гэж байгаа үгийг ч хүлээж авахгүй. Манай хоёр улсын асуудлыг ярих нь зүйтэй биз дээ?

ИДЭНБАЛ: Хоёр улсын харилцааны тухай ярих нь зүйтэй. Намуудын хоорондох зөрөлдөөний тухай асуудлыг ярихаа одоо болье.

ЧЖОУ ЭНХ-ЛАЙ: Хоёр нам үзэл суртлаар еер байлаа ч гэсэн хоёр улсын харилцаа хэвээр байх ёстой.

ИДЭНБАЛ: — Зөв.

ЧЖОУ ЭНХ-ЛАЙ: Зарим нэг бусад оронтой тиймгүй шүү.

ИДЭНБАЛ: Танай нам ах дүү намуудтай зарим чухал асуудал дээр зөрөлдөөнтэй байгааг бид мэдэж байна. Энэ тухай ярихаа болье. Намуудын хоорондын харилцааг сайжруулахад Албанийн асуудлыг тусгаарлаад бусад ойртож болох асуудлаар ярих хэрэгтэй юм.

ЧЖОУ ЭНХ-ЛАЙ: Албанийн нам чинь марксист-ленинист нам шүү дээ. Яагаад тусгаарлах юм вэ?

ИДЭНБАЛ: Түүнийг жич шийдвэрлэх хэрэгтэй юм, намуудын хоорондын харилцааны асуудлыг шийдвэрлэхэд Албанийн асуудлаар хослой дээрээ тээглүүр болгож болохгүй.

ЧЖОУ ЭНХ-ЛАЙ: Албанийн асуудлыг ч шийдвэрлэх хэрэгтэй. Бусад асуудлыг ч шийдвэрлэх хэрэгтэй. Дэлхий дээр ямар нэг жижиг улсуудын намыг хүндэтгэхгүй доромжлох байдал гараад байна.

ИДЭНБАЛ: Би тэгэж доромжилье гэж яриагүй шүү.

ЧЖОУ ЭНХ-ЛАЙ: Хрущев чинь нэдтай яриад байсан шүү дээ. Манай хоёр улсын их нам л хоорондоо шийдвэрлэчихвэл ганц сая хүнтэй Албанийн жижиг нам хамаагүй гэж яриад байсан шүү дээ.

-38-


25.

ЦЭДЭНБАЛ:

Би таныг сайн ойлголлоо. Одоо хүлээн авалтын цаг боллоо. Одоо энэ яриагаа болье, бидний байгуулсан гэрээ хоёр улсын найрамдалд чухал ач холбогдолтой боллоо. Ингэж саналаа солилцсон явдалд талархлаа илэрхийлье. /илэрхийлье гээд босов/. Дараа нь бүх хүмүүс гараа барилцан н.Цэдэнбал Чжоу Эн-лайг үүдэн дээр гаргаж өгөв.

Уулзалт яриа 17 цаг 45 минутад дуусав. /18 цагаас элчин сайд Цэвэгмидээс хийх хүлээн авалт эхлэх байсан тул яриат үүгээр дууставар болгов/.

ТЭМДЭГЛЭЛ БЭЛТГЭСЭН



С. БАГАА

1962 - 12 - 29.